



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар Д/546

Хэрлэн сум

“Хөдөөгийн багш нарын спортын ХХ”  
наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны Хорьдугаар хуралдааны 07 тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол шинжлэх ухааны газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянхонгор аймагт зохион байгуулагдах “Хөдөөгийн багш нарын спортын ХХ” наадамд оролцох баг бүрэлдэхүүнд зориулан 4,381,000 (дөрвөн сая гурван зуун наян нэгэн мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Чадварлаг багш, чанартай боловсрол” арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 30-ны  
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардал	Явах км	Зарцуулах шатахуун	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахууны зардал	1960 км	781 литр	3690	2,881,000
2	Эрхийн төлбөр			1,500,000	1,500,000
	НИЙТ				4,381,000